



# ЦЭРГИЙН ДҮРЭМТ ХУВЦАС ӨМСӨХ ДҮРЭМ

**Цуврал №2**  
**Албаны дүрэмт хувцсыг  
өмсөж хэрэглэх**

2026 он



## Албаны дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх

Алба хаагч албаны үүрэг гүйцэтгэх үед өдөр тутам өмсөж хэрэглэх зориулалт бүхий хувцас, хэрэглэлийг хэлнэ.

Албаны дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх цаг, улирлаас хамааран дулааны, хүйтний улирлын болон сэрүүний үеийн гэж ангилна.





## Албаны дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Зүүн ханцуйнд байгууллагын ялгах тэмдэг, Mongolia тэмдэг, баруун ханцуйнд анги, байгууллагын ялгах тэмдэг, энгэрийн баруун талд нэрийн тэмдэг (хуванцар), сургууль төгссөн тэмдэг, зүүн талд одон, медалийн тууз байна.

Албаны хүрэм өмссөн тохиолдолд одон, медалийн тууз, сургууль төгссөн тэмдэг зүүхгүй.



## Албаны дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Албаны китель, өмд, (юбка)-ийг албаны малгай, албаны цамц (урт ханцуйтай), албаны зангиа, өмдний тэлээ, зуны гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Гадаад улсад томилолтоор ажиллах, суралцах үед болон захирагч (дарга)-ийн шийдвэрээр майхан малгай, берет малгайтай хослуулан өмсөж болно.

Захирагч (дарга) тогтоож өгөөгүйгээс бусад үед эмэгтэй алба хаагч юбка өмсөнө.



## Албаны дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Албаны хүрмийг майхан малгай, футболк, албаны өмд, өмдний тэлээ, зуны гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Захирагч (дарга)-ийн шийдвэрээр албаны малгай, берет малгайтай хослуулан хэрэглэж болно.

Албаны хүрмийн цахилгааныг энгэрийн залгаа оёдлоос дээш 50 мм хэмжээтэй татна.

Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед өмсөж хэрэглэнэ. Захирагч (дарга)-ийн шийдвэрээр нэгдсэн ажиллагаанд өмсөж болно.



## Албаны дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Албаны цамц (богино ханцуйтай)-ыг албаны малгай, албаны өмд, зуны гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Энэ тохиолдолд албаны зангиа зүүхгүй, цамцны дээд талын нэг дэх товчийг тайлж өмсөнө.

Захирагч (дарга)-ын шийдвэрээр майхан малгай, берет малгай, саравчтай малгайтай хослуулан өмсөж болно.



## Албаны дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Албаны цамц (урт ханцуйтай)-ыг албаны китель өмссөн үед өмсөх ба ханцуйд ялгах тэмдэг болон чимэг хэрэглэл зүүхгүй, албаны зангиа, зангианы хавчаартай өмсөнө.

Китель өмсөөгүй үед цамцны мөрдэс, албаны зангиа (зангианы хавчаар)-тай өмсөнө.



## Албаны дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Захтай футболкийг саравчтай малгай, албаны өмд, юпкатай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед өмсөж хэрэглэнэ.

Нэгдсэн ажиллагааны үед захирагч (дарга)-ийн шийдвэрээр өмсөж болно.

Алба (цамц)-ны мөрдэс, зүүн ханцуйнд байгууллагын, баруун ханцуйнд анги, байгууллагын ялгах тэмдэг байна.



## Албаны дүрэмт хувцсыг сэрүүний үед өмсөж хэрэглэх



Гурвалжин захтай майкыг албаны китель өмссөн үед өмсөнө.

Ноосон цамцыг албаны хүрэм өмссөн үед цамцны мөрдэстэй өмсөнө.



## Албаны дүрэмт хувцсыг сэрүүний үед өмсөж хэрэглэх



Савхин дээлийг сэрүүний үед албаны хувцас, хэрэглэл дээр цегейк захгүй, албаны малгай, хүзүүний ороолт, савхин мөрдэс, савхин бээлийтэй өмсөнө.



## Албаны дүрэмт хувцсыг сэрүүний үед өмсөж хэрэглэх



Албаны дулаан хүрмийг сэрүүний үед албаны хувцас, хэрэглэл дээр юүдэн, доторгүйгээр албаны малгай, савхин бээлий, албаны мөрдэстэй өмсөнө.

Захирагч (дарга)-ийн шийдвэрээр берет малгайтай хослуулж өмсөж болно.

Албаны мөрдэс, зүүн ханцуйнд байгууллагын, баруун ханцуйнд анги, байгууллагын ялгах тэмдэг байна.



## Албаны дүрэмт хувцсыг хүйтний улиралд өмсөж хэрэглэх



Гурвалжин захтай майкыг албаны китель өмссөн үед өмсөнө.

Ноосон цамцыг албаны хүрэм өмссөн үед цамцны мөрдэстэй өмсөнө.



## Албаны дүрэмт хувцсыг хүйтний улиралд өмсөж хэрэглэх



Албаны дулаан хүрмийг хүйтний улиралд албаны китель, хүрэм, өмд, юбка дээр юүдэн, дотортойгоор өвлийн малгай, савхин бээлий, өвлийн гутал, албаны мөрдэстэй өмсөнө.

Албаны мөрдэс, зүүн ханцуйнд байгууллагын, баруун ханцуйнд анги, байгууллагын ялгах тэмдэг байна.



## Албаны дүрэмт хувцсыг хүйтний улиралд өмсөж хэрэглэх



Савхин дээлийг хүйтний улиралд албаны китель, хүрэм дээр хувцас, хэрэглэл дээр юүдэн, дотортойгоор өвлийн малгай, савхин бээлий, өвлийн гутал, савхин мөрдэстэй өмсөнө.



## Чимэг, хэрэглэл зүүж хэрэглэх

Нэрийн тэмдэг (хуванцар)

### Х.ТЭМҮҮЛЭН

Албаны китель, хүрэм, богино ханцуйтай цамцны баруун энгэрийн халаасны тагны дээд ирмэгт нэрийн тэмдгийн доод ирмэгийг тулган зүүнэ.

Mongolia тэмдэг (хатгамал)



Албаны китель, богино ханцуйтай цамц дээрх байгууллагын ялгах тэмдгээс дээш 10 мм зайд тогтооно.

Байгууллагын ялгах тэмдэг (хатгамал)



Албаны китель, хүрэм, албаны дулаан хүрмийн зүүн ханцуйны мөрний залгаа оёдлоос 120 мм зайд, албаны богино ханцуйтай цамц, захтай футболкны зүүн ханцуйны мөрний залгаа оёдлоос 70 мм зайд тус тус тогтооно.



## Чимэг, хэрэглэл зүүж хэрэглэх

### Одон, медаль, тэмдгийн тууз



Албаны китель, богино ханцуйтай цамцны зүүн энгэрийн халаасны тагны дээд ирмэгт одон, медаль, тэмдгийн доод ирмэгийг тулгаж, голлуулан зүүнэ.

### Сургууль төгссөн тэмдэг



Сүүлд сургууль төгссөн тэмдгийг зүүх ба албаны китель дээр баруун энгэрийн халаасны тагны дээд талд, халаасны товчийг голлуулан, доод үзүүрийг нэрийн тэмдэг (хуванцар)-т тулгаж зүүнэ.

### Анги, байгууллагын ялгах тэмдэг (хатгамал)



Албаны китель, хүрэм, албаны дулаан хүрмийн баруун ханцуйны мөрний залгаа оёдлоос 120 мм зайд, албаны богино ханцуйтай цамц, захтай футболкны зүүн ханцуйны мөрний залгаа оёдлоос 70 мм зайд тус тус тогтооно.



## Одон медаль, тэдгээрийн тууз зүүх

✓ Монгол Улсын баатрын “Алтан таван хошуу” болон Хөдөлмөрийн баатрын “Алтан соёмбо” тэмдэг, Сүхбаатарын одонг албаны китель дээр одон медалийн тэмдгийн туузын дээр зүүнэ;

✓ Хүндэт тэмдгийг захны бартааны өнцгийн түвшинд, салбарын тэргүүний ажилтан тэмдгийг сүүлд төгссөн сургуулийн тэмдэгтэй зэрэгцүүлэн албаны кителийн баруун энгэрт зүүнэ;

✓ Албаны китель дээр спортын мастерын тэмдгийг сүүлд төгссөн сургуулийн тэмдэгтэй зэрэгцүүлэн зүүж болно;

✓ Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын дурсгалын тэмдгийг цэргийн дүрэмт хувцсан дээр зүүхгүй.

Эмэгтэй алба хаагч дулааны улиралд биеийн өнгөтэй, сэрүүний үе болон хүйтний улиралд хар өнгийн (ноосон) трико өмсөнө.



**АНХААРАЛ  
ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА**